

"ДБЭХС" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн дарга зөвлөл Б.ХУЯГЦОГТ



ДОТООД АУДИТОРЫН АЖЛЫН УДИРДАМЖ

2025.11.03

Хэрлэн сум

1. Нийтлэг үндэслэл: "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төлөвлөгөө, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудиторын ажиллах журмын 2.1. дэх заалтыг үндэслэн хийнэ.
2. Дотоод аудитын зорилго: "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн хэрэгжүүлж байгаа эсэхэд шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх.
3. Дотоод аудитын хамрах хүрээ: "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Худалдан авах ажиллагааны хэлтэс
4. Дотоод аудитын хамрах хүрээний хязгаарлалт: "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Худалдан авах ажиллагааны хэлтсийн 2025 оны үйл ажиллагаа хамаарна.
5. Дотоод аудитын ажлын хэсгийн бүрэлдэхүүн: "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитор
6. Хэрэгжүүлэх хугацаа 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийг дуустал
7. Дотоод аудитыг хэрэгжүүлэх гол үе шат: Дотоод аудитын тайлан бэлтгэж, аудитын хороонд танилцуулан батлуулах, аудитын үр дүнг эргэн хянах.
8. Үүрэг хариуцлага: Шаардлагатай мэдээлэл, материал, санхүүгийн баримт материалыг аудиторт шаардсан хугацаанд гаргаж өгөх. Дотоод аудиторын тайлангийн төсөлтэй танилцаж, санал, тайлбар өгөх, аудитын хорооноос гарсан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх.
9. Дотоод аудитын дүнг тайлагнах: Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд танилцуулах, батлуулах, Төлөөлөн удирдах зөвлөл, компанийн гүйцэтгэх удирдлага танилцуулах.

БОЛОВСРУУЛСАН:

ТУЗ-ийн ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТОР  Г.ГАНБҮРГЭД

ДОТООД АУДИТЫН НЭГЖ: ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТОР

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Аудитын нэр: “Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн 2025 оны Худалдан авах
ажиллагаанд хийсэн дотоод аудитын
ажлын тайлан

Аудитын талаарх товч мэдээлэл

Аудит хийгдсэн объект: “ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН
Худалдан авах ажиллагааны хэлтэс

Аудитын төрөл: Гүйцэтгэлийн аудит

Аудитын хугацаа: 2025.11.14-2025.12.03

Аудит хийсэн: Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх
дотоод аудитор Г.Ганбүргэд

И-мэйл хаяг: gganburged2017@gmail.com

Утас: 99103890

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ
3. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
4. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
5. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ
6. ИЛЭРСЭН АСУУДАЛ, ЗӨВЛӨМЖ
7. ӨМНӨ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ
8. ЗӨВЛӨМЖИЙН НЭГТГЭЛ

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу “ДБЭХС” ТӨХК-ийн Худалдан авах ажиллагааны хэлтсийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэлд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитын ажлыг ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитор Г.Ганбүргэд 2025 оны 11 дүгээр сарын 10-наас 12 дугаар сарын 03-ны өдрийг дуустал хугацаанд хийсэн.

ХОЁР.ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

“Аудитын зорилго нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” болон түүний дагуу батлагдсан дүрэм, журамд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөхөд оршино.

Аудитын хамрах хүрээнд “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Худалдан авах ажиллагааны хэлтсийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тендер зохион байгуулалт, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хамруулсан. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөлт бодит хэрэгцээ, хууль тогтоомжид нийцсэн эсэх;
- Тендер зохион байгуулалт, үнэлгээ, шийдвэр гаргалт хууль, журмын дагуу явагдсан эсэх;
- Гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьсан байдал;
- Гарч буй зөрчил, гомдол эрсдэлийн шалтгааныг тодорхойлох;

ГУРАВ.ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/16, 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/238 дугаар тушаал, мөн “ДБЭХС” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/29, 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 114, 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/123, 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 137 дугаар тушаалаар тус тус тодотгол, нэмэлт өөрчлөлт оруулсан боловч эдгээр нь компанийн зорилтот түвшин болон төсвийн ерөнхийлөн захирагчийн тушаал, шийдвэрүүдтэй харилцан уялдаа холбоогүйгээр тодотгож баталсан.

мян.төг

Д/д	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээ	Төсөвт өртөг			Тодотголгосон төсөв	
		Тоо хэмжээ	Батлагдсан	Тухайн онд санхүүжих	Тоо хэмжээ	Төсөвт өртөг
1	Хөрөнгө оруулалт	27	2,666,978	2,666,978	23	2,503,966
2	Их засвараар хийх	5	2,085,192	2,085,192	4	1,435,192
3	ТЗБАХ-ээр хийгдэх ажил	5	168,777	168,777	5	168,777
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй	13	691,706	691,706	15	851,106

5	Бараа худалдан авалт	30	3,951,608	3,951,608	27	3,756,897
6	Бусад худалдан авалт	13	331,092	331,092	13	331,092
7	Сүхбаатар цахилгаан түгээх салбар	11	332,150	332,150	11	332,150
Дүн		104	10,227,503	10,227,503	98	9,379,180

2025 оны ХАА-ний төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан тайлбар

Компанийн 2025 оны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг анх 933.4 сая төгрөгөөр төлөвлөж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан Эрчим хүчний яаманд хүргүүлсэн байна. Гэвч Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/16 дугаар тушаалаар тус зардлыг 306.5 сая төгрөгөөр бууруулж, 626.9 сая төгрөгөөр баталсан.

Уг батлагдсан төсөвт өвлийн хувцас, өвлийн гутлын зардал тусгагдаагүй үлдсэн тул хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 159.4 сая төгрөгийн өртөгтэй өвлийн хувцас, өвлийн гутал худалдан авах төлөвлөгөөг нэмэлт тодотголоор тусгасан байна.

МЯН.ТӨГ

Д/д	Тендер шалгаруулалтын код	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Батлагдсан төсөвт өртөг
1	ДБЭХС/20250102108	Хөдөлмөр хамгааллын өвлийн гутал	Бараа	41,800.00
2	ДБЭХС/20250102109	Хөдөлмөр хамгааллын өвлийн хувцас	Бараа	117,600.00
Дүн				159,400.00

2025 оны ХАА-ний төлөвлөгөөнд хасаж тодотгосон тайлбар

Зарим тендерийг 2–3 удаа зохион байгуулсан боловч оролцогчгүй болсон, мөн компанийн санхүү, мөнгөн урсгалын хүндрэлтэй байдлаас шалтгаалан нийт 262,723.0 мянган төгрөгийн өртөг бүхий худалдан авалтыг төлөвлөгөөнөөс хасаж тодотгосон байна.

МЯН.ТӨГ

Д/д	Тендер шалгаруулалтын код	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр	Төрөл	Батлагдсан төсөвт өртөг
1	ДБЭХС/20250202020	Төмөр бетон тулгуур	бараа	39,900.00
2	ДБЭХС/20250602024	Шинэ конторт хэрэглээний халуун усны шугамд хэрэглэх материал	бараа	18,000.00
3	ДБЭХС/20250602025	Дэд станцын дээврийн засварын материал	бараа	10,112.00
4	ДБЭХС/20250102055	Бульдозерын сэлбэг	Бараа	92,388.00
5	ДБЭХС/20250102062	Шохойн чулуу	Бараа	31,500.00
6	ДБЭХС/20250102064	Авто машины сэлбэг	Бараа	70,823.00
Үнийн дүн				262,723.00

Төлөвлөгөөний товчоо

Д/д	Нэр	Нээлттэй	Харьцуулалт	Шууд	Нэг эх	Нийт дүн
-----	-----	----------	-------------	------	--------	----------

		тендер				худалдан авалт		үүсвэрээс			
		Т/Х	Өртөг	Т/Х	Өртөг	Т/Х	Өртөг	Т/Х	Өртөг	Т/Х	Өртөг
1	Ажил	3	1,357,192	5	279,918	8	114,422	1	33,050	17	1,784,582
2	Бараа	21	5,516,337	29	1,582,854	24	273,215	2	71,712	76	7,444,119
3	Үйлчилгээ					2	17,130	1	35,400	3	52,530
4	Зөвлөх							1	39,600	1	39,600
5	Зөвлөх бус			1	58,349					1	58,349
	Дүн	24	6,873,529	35	1,921,121	34	404,767	5	179,762	98	9,379,180

2025 онд худалдан авах ажиллагааг:

- нээлттэй тендер
- харьцуулалтын арга
- шууд худалдан авалт
- нэг эх үүсвэрийн аргаар зохион байгуулсан байна.

Илэрсэн зөрчил 1:

ДБЭХС/20250402018 дугаартай “Цаг бүртгэлийн систем” 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй программ хангамжийг худалдан авахдаа нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг сонгон гэрээ байгуулж ажилласан байна.

Илэрсэн зөрчил 1: Цаг бүртгэлийн системийн программ хангамжийг худалдан авахдаа харьцуулалтын аргаар тендер зарлахгүйгээр нэг эх үүсвэрийн аргыг сонгож гэрээ байгуулсан байна.

Шалгуур: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 зүйлийн 34.1.Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно.

Зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу тендер зохион байгуулалтын аргыг зөв сонгох.

ДӨРӨВ.ХУДАЛДАН АВАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үнэлгээний хорооны бүрдүүлэлт, үйл ажиллагаа

Компанийн Гүйцэтгэх захирлын холбогдох тушаалаар 2025 онд:

- 3 гишүүний бүрэлдэхүүнтэй **35**,
- 5 гишүүний бүрэлдэхүүнтэй **25**,
- Сүхбаатар Цахилгаан түгээх салбарт 5 гишүүний бүрэлдэхүүнтэй **5** үнэлгээний хороо тус тус байгуулж ажиллуулсан байна.

Үнэлгээний хороонд ажилласан гишүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгалт өгч, **АЗ түвшний сертификат** авсан, хугацаагүй сертификаттай эрх бүхий гишүүд байв.

Төв компанийн үнэлгээний хороонд ажилласан хараат бус гишүүдийн оролцооны байдал дараах байдалтай байна.

Төв компанийн үнэлгээний хороонд ажилласан хараат бус гишүүдийн жагсаалт.

Д/д	Хөндлөнгийн гишүүд	5 гишүүнтэй үнэлгээний хороо	3 гишүүнтэй үнэлгээний хороо	Дүн
1	Б.Дугармаа	15	12	27
2	Б.Хасархүү	17	5	22
3	И.Сийлэгмаа	9	12	21
4	Ц.Амарсанаа	9	6	15
Дүн		50	35	85

Дээрх мэдээллээс харахад **хараат бус нэг гишүүн дунджаар 21 үнэлгээний хороонд** ажилласан нь гишүүдийн ачаалал хэт төвлөрсөн, үнэлгээний чанар, хараат бус байдлын зарчимд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсгэж болзошгүй байна.

2025 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу www.tender.gov.mn сайтад компанийн 98-н ажлын 9,379,179.51 мянган төгрөгийн худалдан авах төлөвлөгөөг нийтэлж, 65-н нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар цахим системд нээлттэй тендер шалгаруулалт, харьцуулалт аргаар, давхардсан тоогоор 104-н удаа зохион байгуулсан байна.

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар-25
- Харьцуулалтын аргаар-79

Тендер зарласан хугацаатай холбоотой зөрчил

Тендер зохион байгуулахдаа tender.gov.mn сайтад нийтэлсэн төлөвлөгөөнд заасан хугацаа болон гүйцэтгэх захирлын тушаалд заасан хугацаанаас хоцроож зарласан тендерийн жагсаалт

Д/д	Тендер шалгаруулалтын код	БАҮ-ний нэр	Зарлах огноо	Зарласан огноо	Хоцорсон хоног
1	ДБЭХС/20250202016	Зуухны тэжээлийн усны пультны гурвалсан хаалт	3/5/2025	3/6/2025	1
2	ДБЭХС/20250101031	Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн В1 давхрын барилгын засвар	3/4/2025	3/6/2025	2
3	ДБЭХС/20250102060	Хэмжих хэрэгсэл	3/5/2025	3/6/2025	1
4	ДБЭХС/20250102061	Цахилгааны материал	3/7/2025	3/11/2025	4
5	ДБЭХС/20250203084	Даатгалын үйлчилгээ	3/5/2025	3/6/2025	1

Илэрсэн зөрчил 2: Тендерийг зохион байгуулахдаа 5-н тендерийг “tender.gov.mn” сайтад нийтэлсэн төлөвлөгөө болон гүйцэтгэх захирлын тушаалд заасан хугацаанаас хоцроож зарласан байна.

Шалгуур: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журын 4.1.5. “төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер шалгаруулалт зарласан эсэх” заалтыг хангахгүй байна.

Зөвлөмж: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төлөвлөгөөнд заасан хугацаанд зарлаж байх.

Тендерийн үр дүнг цахим системд нийтлэхтэй холбоотой зөрчил

Тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд нийтлэхдээ захиалагчийн шийдвэр гарсан өдрөөс хоцроож нийтэлсэн тендерийн жагсаалт

Д/д	Тендер шалгаруулалтын код	БАҮ-ний нэр	Гэрээ байгуулах эрх олгосон огноо	Үр дүн нийтэлсэн огноо	Хоцорсон хоног
1	ДБЭХС/20250102008	Компьютер техник хэрэгсэл	3/14/2025	3/16/2025	2
2	ДБЭХС/20250202010	Экскаватор	3/27/2025	3/28/2025	1
3	ДБЭХС/20250202015	Масло цэвэрлэх центрфуг	4/23/2025	4/24/2025	1
4	ДБЭХС/20250202019	Вакум таслуур	4/2/2025	4/3/2025	1
5	ДБЭХС/20250102039	Хөдөлмөр хамгааллын гутал	4/1/2025	4/2/2025	1
6	ДБЭХС/20250202044	Хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн	2/18/2025	2/19/2025	1
7	ДБЭХС/20250102056	Химийн бодис	5/5/2025	5/6/2025	1
8	ДБЭХС/20250102059	Багаж	4/1/2025	4/2/2025	1

Илэрсэн зөрчил 3: Захиалагчийн гаргасан 8-н тендерийн шийдвэрийг үнэлгээний хорооны нарийн бичиг нь шийдвэр гарсан өдөр цахим системд нийтлээгүй байна.

Шалгуур: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журын 4.1.7. “Тендер шалгаруулалтын үр дүнг захиалагчийн шийдвэр гарсан өдөр цахим системд нийтэлсэн эсэх” заалтыг хангахгүй байна.

Зөвлөмж: Тендер шалгаруулалтын үр дүнг захиалагчийн шийдвэр гарсан өдөрт багтаан цахим системд нийтлэх

Архив, баримт бичгийн бүрдүүлэлттэй холбоотой зөрчил

2025 онд 65-н тендер зохион байгуулж тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичигт даалгасан байна. 6-н тендерийн баримт бичгийг холбогдох албан тушаалтанд өгөөгүй байна.

Илэрсэн зөрчил 4: Худалдан авах ажиллагаанд аудит хийхэд тендер зохион байгуулалттай холбоотой тендерийн 6-н баримт ирүүлээгүй. Гүйцэтгэх захирлын тушаалд архивын нэгж үүсгэн хүлээлгэн өгөх хугацаа тодорхойгүй байна.

Шалгуур: Гүйцэтгэх захирлын үнэлгээний хороо байгуулсан тушаалд “Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх” гэж заасан байна.

Зөвлөмж: Тендер зохион байгуулалт дуусмагц сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох ажилтанд хүлээлгэн

өгөх; Гүйцэтгэх захирлын тушаалд архивын баримт бичгийг хүлээлгэн өгөх хугацааг тодорхой зааж өгөх.

**Тендер зохион байгуулалтын явцад 6-н компани захиалагчийн
шийдвэрт үл нийцэж Сангийн яаманд гомдол гаргасан**

Д/д	Тендерийн дугаар	Тендерийн нэр	Гомдол гаргагч	Сангийн яамны шийдвэр		Гомдлын товч утга	Сангийн яамны гомдол шийдвэрлэсэн байдал	Сангийн яамны дүгнэлт	Захиалагчийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	ДБЭХС/ 20250102002	Цахилгаан шугам сүлжээний засварын материал	Ноёнсайхан ХХК	4/9/2025	02/2667	1.Хүчний трансформаторын богино залгааны алдагдлын утга байвал зохих утгаас хэтэрсэн нь шаардлагад нийцэхгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэртэй санал нийцэхгүй.	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй	1.Хүчний трансформаторын богино залгааны алдагдлын утга байвал зохих утгаас хэтэрсэн нь шаардлагад нийцэхгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэртэй санал нийцэхгүй.	Захиалагч 2025 оны 04 дүгээр сарын 17-ны 01/438 албан бичгээр тодруулга авч үнэлгээний хороо хянан үзэж өмнөх шийдвэрийг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн байна.
						2.Шалгарсан Тамирбулаг ХХК-ийн тендер баримт бичгийн 5-н заалтыг хангахгүй, баримт бичиг хуурамчаар үйлдсэн байгаа талаар дурдаж хянан үзэхийг Сангийн яамнаас хүссэн гомдол гаргасан.	Ноён сайхан ХХК-ийн Гаргасан 2 гомдол үндэслэлгүй	2.Шалгарсан Тамирбулаг ХХК-ийн тендер баримт бичгийн 5-н заалтыг хангахгүй, баримт бичиг хуурамчаар үйлдсэн байгаа талаар дурдаж хянан үзэхийг Сангийн яамнаас хүссэн гомдол гаргасан.	
							Тамир булаг ХХК-ийн тендерийг 2 заалтыг тодруулж хянаж үзэх		
							Тамир булаг ХХК-ийг шалгаруулсан 1 заалт үндэслэлгүй		
							Тамир булаг ХХК-ийг 1 заалтыг хянан үзээгүй		

2	ДБЭХС/ 20250102017	Авто ачигч /Ковш/	Эйч ди эс юу ХХК	2/27/2025	02/1471	2024 оны Санхүүгийн тайлан ирүүлээгүй гэж татгалзсан	Санхүүгийн тайлан ирүүлээгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй	Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01/112 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж, Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье гэжээ	Үнэлгээний хороо хянан үзэж Эйч ди эс юу компанийг шалгаруулсан байна.
3	ДБЭХС/ 20250102054	Төмөр	Аспен хунт ХХК	5/9/2025	02/4005	Дорнын үндэс ХХК-ийн 2024 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлээгүй байхад шалгаруулсан захиалагчийн шийдвэр хянан үзэх Дорнын үндэс ХХК нийлүүлэгдэх бараатай холбоотой баримт бичиг ирүүлээгүй байхад шалгаруулсан Бараа нь стандартыг хангах нотлох баримт бичиг ирүүлээгүй	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна. Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй 2 заалт	Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон 2025 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн 01/453 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж, Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь	Үнэлгээний хороо хянан үзэж Сангийн яамны гомдол хянасан нь тендерийн үнэлгээтэй хамааралгүй бараа нийлүүлэгдэх үед шаардах баримт бичиг гэж үзэж өмнөх шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

								заалтыг үндэслэн мэдэгдье гэжээ	
4	ДБЭХС/ 20250203084	Даатгалын үйлчилгээ	ХААН даатгал ХХК	4/22/2025	021/3212	Практикал даатгал ХХК 57,9 төгрөг болон 56,9 сая төгрөгийн үнэ санал болгож хувилбарт санал ирүүлсэн	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.	Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон 2025 оны 04 дугаар сарын 02-ны өдрийн 01/369 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж, Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье гэжээ	Тус тендерийг хүчингүй болгож тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулж Практикал даатгал ХХК-г сонгон шалгаруулсан.
						ТШЗ 18.1-д "ДБЭХС" ТӨХК-тай гэрээ байгуулсан бол сүүлийн 2 жилийн гэрээ дүгнэсэн акт ирүүлээгүй	ХААН даатгал ХХК-ын гомдол нь үндэслэлгүй байна		
						Автомашинны замын хөдөлгөөнд оролцуулах, зогсоолд байршуулах, гражид хадгалах үед учирсан дараах эрсдэлүүд дугуйн эрсдэл гэж заасан	Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй		
						Даатгалын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар /нотариатаар/ баталгаажуулсан гэж заасан	Захиалагч /www.licese.mn/- ээс хянан үзээгүй байна		
5	ДБЭХС/ 20250102058	Давс	Эм Си Жи трейд ХХК	4/24/2025	02/3271	Эм Си Жи трейд ХХК-ийн Тусгай зөвшөөрөлгүй гэж татгалзсан.	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.	Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон 2025 оны 04 дүгээр	Тус тендерийг хүчингүй болгож тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулж Давст-Оргил ХХК-г сонгон
						Давст-Оргил ББН-ийн тендерийн баримт бичгийн шаардлага хангагүй гэж 6-н	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй 5 заалт		

						заалтаар гомдол гаргасан	Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй 1 заалт	сарын 17-ны өдрийн 01/432 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж, Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.3 дахь заалтыг үндэслэн мэдэгдье гэжээ	шалгаруулсан.
6	ДБЭХС/ 20250202047	Хөдөлмөр хамгааллын бээлий	Монайжин солюшнс ХХК	3/18/2025	02/1827	Гэрээ байгуулах эрх олгосон Мандарваа мандал ХХК ТББ-ийн 12.2 хангаагүй, стандарт хангасан эсэхийг нотлох баримт ирүүлээгүй	Монайжин солюшнс ХХК-ийн гаргасан гомдол нь үндэслэлгүй байна	Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/165 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж, Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье гэжээ	Үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу Монайжин солюшнс ХХК-ийг шалгаруулсан байна.
							Техникийн үзүүлэлтийг хангасан гэж үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй		

Худалдан авах ажиллагаатай холбоотой ирүүлсэн гомдлыг Сангийн яамнаас хянан үзэж, **нийт 6-н албан бичгээр 23 заалт бүхий зөвлөмж** ирүүлсэн байна. Уг зөвлөмжөөр гомдол тус бүрийг дараах байдлаар ангилан шийдвэрлэсэн байна. Үүнд:

- **Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй** гэж үзсэн – **13 шийдвэр**
- **Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй** гэж үзсэн – **6 шийдвэр**
- **Нэмэлт тодруулж үнэлгээ хийх шаардлагатай** – **2 шийдвэр**
- **Хянан үзээгүй** – **2 шийдвэр**

Сангийн яамны дүгнэлтээр:

- Тендерийн материалд тавигдсан шалгуур, шаардлагыг буруу тайлбарласан
- Санхүүгийн тайлан, тусгай зөвшөөрөл, стандарт хангасан эсэхийг нотлох баримтыг дутуу буюу огт хянаагүй,
- Зарим оролцогчийг үндэслэлгүй татгалзсан, эсхүл шаардлага хангаагүй этгээдийг шалгаруулсан зөрчлүүд удаа дараа илэрсэн байна.

Үүний үр дүнд:

- 4 тендерт анхны шийдвэрийг дахин хянан үзсэн боловч зарим тохиолдолд Сангийн яамны дүгнэлтийг бүрэн хэрэгжүүлэлгүй өмнөх шийдвэрийг хэвээр үлдээсэн,
- 2 тендерийг хүчингүй болгож, дахин тендер шалгаруулалт зохион байгуулсан байна.

Илэрсэн зөрчил 5: Сангийн яамнаас хянан үзсэн **6-н гомдлыг гомдол гаргагчийн талд шийдвэрлэсэн** нь үнэлгээний хорооны анхан шатны үнэлгээ, захиалагчийн шийдвэр хангалттай үндэслэлтэй байгаагүйг харуулж байна.

Шалгуур: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 4.1.11-д заасан “гэрээ байгуулах эрх олгосон асуудлаар гаргасан гомдлыг захиалагчийн талд шийдвэрлэсэн эсэх” гэсэн шаардлагыг хангаагүй.

Зөвлөмж: Үнэлгээний хорооны гишүүдийн мэргэжлийн чадавхыг нэмэгдүүлэх, тогтмол сургалт, давтан үнэлгээ хийх;

Хараат бус, хөндлөнгийн гишүүдийн тоог нэмэгдүүлж, бодит оролцоог хангах;

Нэг гишүүнийг олон тооны тендерийн үнэлгээнд давтамжтай оролцуулахыг хязгаарлаж, үнэлгээний хорооны гишүүдийн ачааллыг тэнцвэржүүлэх;

Үнэлгээний баримт бичгийн үндэслэл, тайлбарыг сайжруулж, гомдол гаргах эрсдэлийг бууруулах.

Тендерийн баримт бичгийн үнэ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2025 онд тендерийн баримт бичгийн үнийг баталж, уг үнийн дагуу тендерийн баримт бичиг борлуулснаар нийт 7,420.0 мянган төгрөгийн орлогыг холбогдох журмын дагуу төвлөрүүлсэн байна.

ТАВ. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 онд худалдан авах ажиллагааны хүрээнд:

- Тендер шалгаруулалтын аргаар – **62**,
- Шууд худалдан авалтаар – **28**,
- Нэг эх үүсвэрийн аргаар – **6**, нийт **102** компанитай ажил гүйцэтгэх болон бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулж ажилласан байна.

Нийт 102 нэр төрлийн, 9,379,180.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тендер сонгон шалгаруулалтын үр дүнд батлагдсан төсөвт өртгийг 720,304.0 мянган төгрөгөөр хэмнэж, 8,658,875.0 мянган төгрөгийн дүнтэй гэрээ байгуулсан байна.

Мян.төг

Д/д	Нэр	Т/Х	Гэрээ байгуулсан	Гэрээгүй	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Хэмнэлт
1	НТШ	28	28	-	6,873,529	6,395,699	(477,830)
2	ХА	34	34	-	1,896,121	1,740,215	(155,906)
3	ШХА	34	28	6	404,767	324,299	(80,468)
4	НЭҮ	6	6	-	204,762	198,662	(6,100)
	Дүн	102	96	6	9,379,180	8,658,875	(720,304)

Гэрээ байгуулалтын явцад нийт төсөвт өртгөөс 720.3 сая төгрөгийн хэмнэлт гаргасан нь санхүүгийн хувьд эерэг үр дүн боловч шууд худалдан авалтын 6 тендер гэрээ байгуулагдаагүй үлдсэн нь санхүүгийн урсгалын уялдаа сул байсныг харуулж байна. Нэг эх үүсвэрийн аргаар байгуулсан гэрээнүүдэд онцгой нөхцөл, үндэслэлийг илүү тодорхой баримтжуулах шаардлагатай байна.

Шууд худалдан авалт

Мян.төг

Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	Хүчилтөрөгчийн коктейль	14,394	9,603	(4,791)	
2	Компьютерын дагалдах хэрэгсэл	19,774	4,591	(15,183)	
3	Хангамжийн өргөн хэрэглээ	14,610	2,715	(11,895)	
4	Ерөнхий хэрэглээний зардал	13,075	3,839	(9,236)	
5	Төрөл бүрийн хий	11,658	7,195	(4,463)	
6	Бичиг хэргийн дагалдах хэрэгсэл	8,168	3,362	(4,806)	
	Дүн	81,679	31,304	(50,375)	

Төсөвт өртөг 81,678.7 мянган төгрөг гүйцэтгэл 31,304 мянган төгрөг гарч 50,375 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Аудитаар 2025 оны худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй дараах худалдан авалтууд хийгдсэн байна.

МЯН.ТӨГ					
Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Гүйцэтгэгч	Гэрээний дугаар	Гэрээний дүн	Гүйцэтгэл
1	Нүүрс	Найнги ХХК	ХА/2025/01		16,767,624
2	Нүүрс	Адуунчулуун ХК	ХА/2025/02		100,254
3	Нүүрс	МАК ХХК	ХА/2024/12		13,058,481
4	Нүүрс тээвэр	Энгүй заяач ХХК	БГ/2024/27		781,789
5	Нүүрс тээвэр	Нарма ХХК	БГ/2024/26		729,148
6	Тоолуурын батерей солих, программчлах	Эталон хэмжүүр ХХК	АГ/2025/23	52,080	49,720
7	Харуул хамгаалалтын хэрэгсэл	Саст Тактикал ХХК	ХА/2025/05	9,075	9,075
8	Харуул хамгаалалтын хэрэгсэл	Нанопланет ХХК	ХА/2025/06	1,860	1,860
9	Харуул хамгаалалтын Компьютер	Сүү хүнгий ХХК	ХА/2025/07	3,175	3,175
10	Суурин компрессор ВП2-10/9 75кВт	Баян баядын залуус	ХА/2025/08	9,350	9,350
11	Автомашин механизмын дугуй, аккумулятор	Прайм тэгш эхлэл ХХК	ХА/2025/56	16,860	16,860
12	Ланд-200 маркийн машины сэлбэг	Прайм тэгш эхлэл ХХК	ХА/2025/59	10,659	10,659
13	Сумдын шатахуун худалдан авах	Нефть хангамжийн салбар	БГ/2025/28	8,420	8,420
Дүн				111,479	31,546,415

Автомашин сэлбэг хэрэгслийг худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнөөс хасаж тодотгосон атлаа Ланд 200 маркийн автомашины сэлбэг, автомашин механизмын дугуй, аккумуляторыг төлөвлөгөөнд тусгагдаагүйгээр худалдан авсан нь төлөвлөлт, хэрэгжилтийн уялдаа хангагдаагүй байна.

Илэрсэн зөрчил 6: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 13-н ажлын 31,546,415.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн.

Шалгуур: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйл. Худалдан авах ажиллагааг төлөвлөх 44.1.Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.

Зөвлөмж: Сумдын бензин колонкоос шатахуун авах шаардлага жил бүр гардаг. Тус шатахууны худалдан авалтыг төлөвлөгөөнд тусгах, төлөвлөгөөгүй худалдан авалт хийхгүй байх.

2025 оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 96 компанитай гэрээ байгуулж 80 компанийн гэрээгээ дүгнэж, 16 компанийн гэрээ хэрэгжих шатанд, шууд худалдан авалтаар 6 компаниас бараа маериал худалдан авч байна.

Д/д	Гэрээний хэрэгжилт	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	гэрээний дүн	Гүйцэтгэл	Хийгдээгүй худалдан авалт
1	Гэрээ дүгнэгдсэн	80	7,380,586	6,937,741	6,922,128	15,613
2	Хэрэгжиж буй гэрээ /2026 онд дүгнэх/	16	1,916,915	1,721,134	835,800	885,334
3	Шууд худалдан авалт	6	81,679		-	-
Дүн		102	9,379,180	8,658,875	7,757,928	900,947

Гэрээнд “бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хоног тутам гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.2 хувьтай тэнцэх хэмжээний алданги

ногдуулах” гэж заасны дагуу дараах аж ахуйн нэгжүүдэд хугацааны алданги тооцсон байна.

Нийт дүн:

- Гэрээний нийт дүн – **2,281,333.0** мянган төгрөг
- Хугацаандаа нийлүүлээгүй үнийн дүн – **748,700.0** мянган төгрөг
- Тооцож ногдуулсан алдангийн нийт дүн – **33,788.0** мянган төгрөг

Д/д	ААН нэр	Гэрээний дугаар	Ажлын нэр	Нийлүүлэх эцсийн хугацаа	Гэрээний дүн	Нийлүүлээгүй үнийн дүн	Алданг и тооцох хувь	алданг и тооцох хоног	Алдангийн дүн
1	Грийн электроник инженеринг ХХК	ДБЭХС/202 50102001	"Чойбалсан-Баруун Урт" 110кВ-ын ЦДАШ-ын засварын материал	5/14/2025	519,893	4,345	0.2%	38	330
2	Тамир булаг ХХК	ДБЭХС/202 50102002	Цахилгаан шугам сүлжээний засварын материал	5/9/2025	240,680	240,680	0.2%	9	4,332
						1,100	0.2%	11	42
3	Билэг дизайн ХХК	ДБЭХС/202 50102039	Хөдөлмөр хамгааллын гутал	4/14/2025	124,201	124,201	0.2%	4	994
4	Шунхлай ХХК	ДБЭХС/202 50102053	Мазут	7/1/2025	799,200	113,681	0.2%	56	12,732
5	Эн Эй Эн Ди Ай Эн ХХК	ДБЭХС/202 50102059	Багаж	4/7/2025	133,748	1,081	0.2%	39	84
						1,221	0.2%	46	112
6	Талын сүлд ХХК	ХА/2025/17	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	5/13/2025	96,322	6,162	0.2%	6	74
7	Викиворлд ХХК	ХА/2025//19	Зуухны тээрмийн алх, нүүрс тэжээгчийн хамагч гинж	5/15/2025	68,717	68,717	0.2%	6	999
8	зүүн богд хайрхан ХХК	ХА/2025/25	Цэвэрлэгээний шүүр	4/22/2025	8,640	4,320	0.2%	7	60
9	Альфа филтер ХХК	ХА/2025/30	Хөдөлгүүрийн агаар шүүгч	5/23/2025	5,526	5,526	0.2%	100	1,105
10	Цэцүүх трейд ХХК	ХА/2025/39	Химийн урвалж, туслах материал	7/14/2025	32,975	32,975	0.2%	89	5,869
11	Реактив ХХК	ХА/2025/40	Химийн бодис	7/13/2025	85,721	33,269	0.2%	9	599
12	Хурд инженеринг ХХК	ХА/2025/41	Сальник парнит	7/5/2025	52,680	52,680	0.2%	24	2,529
						24,152	0.2%	53	2,560
						10,192	0.2%	62	1,264
13	Хурд инженеринг ХХК	ХА/2025/22		5/28/2025	59,988	46	0.2%	20	2
14	Их чулуун болор ХХК	ХА/2025/42	Электрод, карбид нийлүүлэх	7/5/2025	30,100	1,410	0.2%	3	8
15	Мянган айл цамхаг ХХК	ХА/2025/44	Кабель	6/15/2025	22,943	22,943	0.2%	2	92
Дүн					2,281,333	748,700			33,788

2025 онд гэрээ дүгнүүлсэн 80 компанийн:

- 65 компани гэрээний нөхцөлийг зөрчилгүйгээр, бүтээгдэхүүн нийлүүлэх хугацааг баримтлан үүргээ бүрэн биелүүлсэн

- 15 компани бүтээгдэхүүн нийлүүлэх хугацааг хэтрүүлсэн тул гэрээнд заасан нөхцөлийн дагуу 33,788.0 мянган төгрөгийн хугацааны алданги тооцож, компанийн орлого болгон суутган авсан байна.

Гэрээний дүнгээс хэтрүүлж худалдан авалт хийгдсэн жагсаалт

Мян.төг

Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Гүйцэтгэгч	Гэрээний дугаар	Гэрээ дуусах хугацаа	Гэрээний дүн	Гүйцэтгэл	Зөрүү
1	Шатахуун багц №2	Шунхлай говь ХХК	ДБЭХС/20250102051	4/23/2026	57,043	66,659	9,617
2	Интернэт үйлчилгээний төлбөр	Юнивешн ХХК	БГ/2025/35	10/1/2028	35,400	50,279	14,879
Дүн					92,443	116,938	24,496

ШТМ-ын багц 2 шатахуун худалдан авах гэрээ (ДБЭХС/20250102051)

- Гэрээний 1.3 заалтад “гэрээний нэгж үнэ нь тухайн үеийн шатахуун түгээгүүр станц дээр мөрдөж буй үнийн дүнгээс 8%-н хөнгөлөлттэй байна” гэж заасан.
- Гэрээ хэрэгжих хугацаанд шатахууны үнэ 1 литр нь 2,530–2,730 төгрөг болж өссөн.
- Нийт 28,232.0 литр А-92 шатахуун худалдан авч, үнийн хөнгөлөлт 5,749.6 мянган төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн.
- Гэрээний 4.1 заалтаар “Захиалагч нь гэрээгээр нийлүүлэх бүтээгдэхүүний тоо хэмжээг 20%-р өсгөх/бууруулах эрхтэй” гэж заасан бөгөөд гэрээний үүргийн биелэлт 20%-аас хэтэрсэн тул цаашид А-92 бензин хөнгөлөлтгүй үнээр худалдан авах нөхцөл бүрдсэн.

Илэрсэн зөрчил 7: 2025 оны 12 дугаар сард гэрээний хэрэгжилт бүрэн дуусч, дараагийн тендер зохион байгуулах хүртэл хугацаанд үнийн хөнгөлөлтгүй шатахуун худалдан авах шаардлага үүссэн.

Шалгуур: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.

Зөвлөмж: 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үнэн зөв тооцоолж хийх, төлөвлөгөөгүй худалдан авалт хийхгүй байх.

ЗУРГАА.ӨМНӨ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2024 оны худалдан авах ажиллагаанд хийсэн дотоод аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал.

Д/д	Илэрсэн зөрчил	Мөнгөн дүн /Мян.төг/	Гаргасан шийдвэр	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага,	Зөрчил арилгасан байдал
-----	----------------	----------------------	------------------	--	-------------------------

				зөвлөмжийн товч утга	
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журын 4.1.5.“төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер шалгаруулалт зарласан эсэх” заалтыг хангахгүй байна.	-	Зөвлөмж	Тендер зохион байгуулахдаа Дулааны хоёрдугаар магистраль шугам, Зуухны тээрмийн алх баригч, Хаалт гэсэн 3-н ажлыг төлөвлөгөөнд заасан хугацаанаас хоцорч зарласан байна.	Дулааны II магистраль шугам, хаалт худалдан авах тендерийн хувьд хугацаа хоцорсон шалтгаан нь тухайн тендерүүдийн нарийн бичиг Ж.Гантулга нь цахим системд нэвтрэх боломжгүй болсноос үнэлгээний хорооны нарийн бичгийг Гүйцэтгэх захирлын А/67 тоот тушаалаар үүрэгт ажлаас чөлөөлж Инженер Т.Түвшинхүүг томилж ажиллуулсан. Тус шалтгааны улмаас хугацаа хоцорсон. Харин зуухны тээрмийн алх баригчийн хувьд хугацаа хоцорч зарлаагүй хугацаандаа зарласан болно. 2025 онд хугацаа хоцорч зарласан тендер байхгүй.
2	Зүүн Богд Хайрхан ХХК-ийн байгуулсан ХА/2024/08 дугаартай гэрээний /6.4.Энэхүү гэрээний үйлчлэх хугацаанд хүлээсэн үүргээ биелүүлэхээс нэг тал үндэслэлгүйгээр татгалзсан бол буруутай тал нөгөө талдаа 5 хувьтай тэнцэх хэмжээний торгууль төлнө./ гэсний дагуу хэрэгжээгүй үнийн дүн буюу 9,276.7 төгрөгийн 5 хувь 463.8 мянган төгрөгийн торгууль төлүүлээгүй байна	463.8	Зөвлөмж	Зүүн Богд Хайрхан ХХК-нд гэрээний дагуу хариуцлага тооцоож ажиллах, ХАБЭА-н тухай хуулийн 28 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн эрх, үүргийг биелүүлж ажиллах.	Зүүн богд хайрхан ХХК нь 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр “гэрээний 7.2-т заасны дагуу нөхцөл байдал үүссэн тул гэрээ цуцлах хүсэлтэй байна” гэсэн албан бичиг ирүүлснээр гэрээг цуцалсан. 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Дээшлэх нар ХХК-тай үнийн саналын дагуу гэрээ байгуулсан.
3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журын 4.1.9.“Худалдан авах гэрээг цахим системд нийтэлсэн эсэх”, 4.1.10.“Гэрээний хэрэгжилтийг цахим системд хөтөлсөн эсэх” заалтыг хангахгүй	-	Зөвлөмж	Худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд гэрээ, гэрээ дүгнэсэн актыг цахим системд оруулах, цахим системээр хөтөлж явуулах.	2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу тендер зарлаж, шалгаруулж гэрээ байгуулсан 95 гэрээ, гэрээ дүгнэсэн актыг цахим системд нийтэлж оруулсан. Цаашид нэмж оруулах гэрээ, гэрээ дүгнэсэн актуудыг тухай бүрд нь оруулан ажиллана.

	байна.				
4	Интер стандарт нефть ХХК-ийн гэрээ дүгнэхдээ гэрээний 6.1. дэх заалтын дагуу 24,676.9 мянган төгрөгийн алданги тооцож, төвлөрүүлээгүй байна	24,676.9	Зөвлөмж	Гэрээний заалтын дагуу алданги тооцож төсөвт төвлөрүүлдэг байх.	2025 онд нийт 63 гэрээ дүгнэсэн. Үүнээс гэрээний хугацаанаас хоцорч нийлүүлсэн 10 гэрээг алдангитай дүгнэсэн. Цаашид хугацаа хоцорч нийлүүлсэн бараа материал ажил, үйлчилгээг гэрээний дагуу алданги тооцож дүгнэж ажиллана.
5	Худалдан авах ажиллагааны тайлангаа shilendans.gov.mn сайтад тайлагнахдаа тогтсон хугацааг хоцроож мэдээлсэн байна	-	Зөвлөмж	Шилэн дансны тухай хууль, журмын дагуу мэдээлэлдэг байх	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор оруулдаг, мөн сар бүрийн 07-ний дотор шилэн данс цахим системд тухайн сард байгуулсан гэрээ болон тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн ашиг сонирхлын мэдүүлгийг оруулж ажиллаж байна. Цаашид төлөвлөгөө, тайлан, мэдээг хоцроохгүй хугацаанд оруулж ажиллана.
6	Гэрээ дүгнэхдээ гэрээний хугацаанаас хоцроож дүгнэж байна	-	Зөвлөмж	Гэрээний хугацаанд багтаан гэрээ дүгнэж дуусгах	2024, 2025 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын маягт-2 /дүгнэх хугацаа тавихгүй болсон/ дагуу төлөвлөгөөний гүйцэтгэлийг гаргаж ажиллаж байна.

ДОЛОО. ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН НЭГТГЭЛ

Д/д	Илэрсэн зөрчил	Мөнгөн дүн /Мян.төг/	Гаргасан шийдвэр	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн товч утга	Зөрчил арилгасан байдал
-----	----------------	----------------------	------------------	---	-------------------------

1	Цаг бүртгэлийн системийн программ хангамжийг худалдан авахдаа харьцуулалтын аргаар тендер зарлахгүйгээр нэг эх үүсвэрийн аргыг сонгож гэрээ байгуулсан байна.	-	Зөвлөмж	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу тендер зохион байгуулалтын аргыг зөв сонгох.	
2	Тендерийг зохион байгуулахдаа 5-н тендерийг “tender.gov.mn” сайтад нийтэлсэн төлөвлөгөөнд заасан хугацаа болон гүйцэтгэх захирлын тушаалд заасан хугацаанаас хоцроож зарласан байна.		Зөвлөмж	Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төлөвлөгөөнд заасан хугацаанд зарлаж байх.	
3	Захиалагчийн гаргасан 8-н тендерийн шийдвэрийг үнэлгээний хорооны нарийн бичиг нь шийдвэр гарсан өдөр цахим системд нийтлээгүй байна.		Зөвлөмж	Тендер шалгаруулалтын үр дүнг захиалагчийн шийдвэр гарсан өдөрт багтаан цахим системд нийтлэх	
4	Худалдан авах ажиллагаанд аудит хийхэд тендер зохион байгуулалттай холбоотой 6-н баримт ирүүлээгүй. Гүйцэтгэх захирлын тушаалд архивын нэгж үүсгэн хүлээлгэн өгөх хугацаа тодорхойгүй байна.		Зөвлөмж	Тендер зохион байгуулалт хийж дуусгаад сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгийн архивын нэгж үүсгэн холбогдох ажилтанд хүлээлгэн өгч аудит хийх боломжоор хангах. Гүйцэтгэх захирлын тушаалд хүлээлгэн өгөх хугацааг тодорхой оруулах	
5	Сангийн яамнаас хянан үзсэн 6-н гомдлыг гомдол гаргагчийн талд шийдвэрлэсэн нь үнэлгээний хорооны анхан шатны үнэлгээ, захиалагчийн шийдвэр хангалттай үндэслэлтэй байгаагүйг харуулж байна.		Зөвлөмж	Үнэлгээний хорооны гишүүдийн мэргэжлийн чадавхыг нэмэгдүүлэх, тогтмол сургалт, давтан үнэлгээ хийх; Хараат бус, хөндлөнгийн гишүүдийн тоог нэмэгдүүлж, бодит оролцоог хангах; Нэг гишүүнийг олон тооны тендерийн үнэлгээнд	

				давтамжтай оролцуулахыг хязгаарлаж, үнэлгээний хорооны гишүүдийн ачааллыг тэнцвэржүүлэх; Үнэлгээний баримт бичгийн үндэслэл, тайлбарыг сайжруулж, гомдол гаргах эрсдэлийг бууруулах.	
6	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 8-н ажлын 109,119.23 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн.	109,119.23	Зөвлөмж	Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батлах. Төлөвлөгөөгүй худалдан авалт хийхгүй байх.	
7	2025 он 12-р сард гэрээний хэрэгжилт бүрэн дуусаж тендер зохион байгуулж компани сонгон шалгаруулах хүртэл үнийн хөнгөлөлтгүй шатахуун авах нөхцөл үүссэн.		Зөвлөмж	2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үнэн зөв тооцоолж хийх, төлөвлөгөөгүй худалдан авалт хийхгүй байх.	

НАЙМ. ДҮГНЭЛТ

2024 оны худалдан авах ажиллагааны аудитын тайлангаар өгсөн зургаан зөвлөмжийн тав нь хэрэгжсэн бөгөөд нэг зөвлөмж нь 2025 оны худалдан авах ажиллагаанд давтан илэрсэн байна. Ингэснээр зөвлөмжийн хэрэгжилт 83 хувийн биелэлттэй байна.

Худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээг эрэмбэлж, бодит хэрэгцээ, санхүүгийн боломжтой уялдуулан үр ашигтай төлөвлөх шаардлага хангалтгүй байгаа нь төлөвлөгөөгүй худалдан авалт хийх, гэрээний дүн хэтрүүлэх нөхцөл үүсэхэд нөлөөлж байна. Энэ нь худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн шаардлагыг зөрчих эрсдэлийг нэмэгдүүлж, байгууллагын санхүүгийн сахилга батад сөргөөр нөлөөлж байна.

Сангийн яамнаас 6 компанийн гомдлыг хянан үзэж дүгнэлт ирүүлсэн бөгөөд үүнд захиалагч тендер зохион байгуулахдаа дутуу үнэлгээ хийсэн, зарим заалтыг хянаагүй байсан зэрэг заалтууд багтсан байна. Мөн үнэлгээний хорооны хараат бус гишүүн дунджаар 21 тендерийн үнэлгээний хороонд ажилласан бөгөөд тендерийн үнэлгээ хийхдээ дутуу хийгдсэн байх эрсдэлтэй байна.

Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх, олон жил дараалан ажиллаж байгаа гишүүдийг сэлгэн томилж ажиллуулах, мөн компанийн ажилтнуудын тендерийн үнэлгээ хийх чадварыг сайжруулахыг зөвлөж байна. Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороонд ирүүлэх шаардлагатай.

ТАНИЛЦСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ө.ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАСАН:

АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА

Э.ГАНБААТАР

АУДИТ ХИЙСЭН:

ДОТООД АУДИТОР

Г.ГАНБҮРГЭД